



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/115

Мөрөн сум

Захирамжийн хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны “Үйл ажиллагааны жагсаалт, төсөвт өртөг батлах тухай” А/45 дугаар захирамжийн хавсралтын 2 дугаар арга хэмжээ хэсэгт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Багийн Засаг дарга нарт олгох мотоцикл”-ын тоо 60 гэснийг цар тахлын улмаас гаалийн ачаа барааны эргэлт муудаж, зах зээлийн үнийн өсөлттэй холбогдуулан 54 гэж өөрчилсүгэй.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар багийн Засаг нарт олгох мотоциклын худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН